



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНД ИРЖ БУЙ ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ТАЛААР

Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтын байгууллагууд болох үнэт цаас, даатгал, бичил санхүүгийн салбарын үйл ажиллагаатай холбоотой хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдээс 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 8 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 228 өргөдөл, гомдол ирсэн байна. Үүнээс салбар тус бүрээр ангилвал:



Дээрх графикаас харахад санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулж буй үндсэн гурван салбаруудад хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдээс ирүүлж буй нийт өргөдөл, гомдлын 50% нь үнэт цаасны салбарт, 39% нь даатгалын салбарт, 11% нь бичил санхүүгийн байгууллагуудад хандан ирж байгаа нь харагдаж байна.

Үнэт цаасны зах зээлийн зохицуулалтын байгууллагуудын үйл ажиллагаатай холбоотой нийт 113 өргөдөл гомдол ирснээс хувьцаат компанийн ногдол ашигтай холбоотой болон брокер, дилерийн компаниар хувьцаа зөвшөөрөлгүй зарагдсан тухай өргөдлүүд дийлэнх хувийг эзлэж байна. Үүнийг графикаар харуулбал:



Харилцагчдаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд хянан шийдвэрлэж харилцагчдын хохирол болох нийт 21,591,480.00 төгрөгийг төлүүлж ажиллаа.

Харин даатгалын салбарын хувьд нийт 90 өргөдөл, гомдол ирснээс жолоочийн хариуцлагын албан журмын, тээврийн хэрэгслийн, эрүүл мэндийн, ипотекийн цогц даатгал, тэтгэврийн даатгалын гэсэн төрлүүдээр нөхөн төлбөртэй холбоотой гомдол ирж байгаа бөгөөд нийт 154,608,180.00 төгрөгийн нөхөн төлбөрийг даатгуулагчдад олгуулж ажиллаа.



Бичил санхүүгийн салбарын хувьд банк санхүүгийн байгууллага болон хадгаламж зээлийн хоршоодын зээл, хадгаламжийн үйл ажиллагаатай холбоотой гомдлууд ирсэн байна.

Санхүүгийн зохицуулах хороо нь Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд зааснаар Санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллага тул иргэд, хуулийн этгээд, хөрөнгө оруулагч үйлчлүүлэгчдээс хувьцаат компанийн ногдол ашиг болон хувьцаа зөвшөөрөлгүй зарагдсан тухай, даатгалын компаниудын нөхөн төлбөр болон бичил санхүүгийн байгууллага тэдний үйл ажиллагаатай холбоотой ирсэн санал, өргөдөл, гомдлыг хүлээн авч хуулийн хүрээнд хянан шийдвэрлэдэг болно.

**ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ,
ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ ХЭЛТЭС**